

## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2021 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

### НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 3 удаа зохион байгуулж, нийт 8 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажилласан. Засаг даргын зөвлөлийн хурлыг зохион байгуулж, аймгийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн 2020 оны жилийн эцсийн тайлан, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2020 оны жилийн эцсийн тайлан, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2020 оны жилийн эцсийн тайланг танилцуулж Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Мөн Улсын аварга малчинд нэр дэвшигчдийн материалтай танилцаж шаардлагад нийцсэн “Улсын хошой аварга малчин өрх”-д 1, “Улсын аварга малчин өрх”-д 2, “Улсын аварга саальчин”-д 1 иргэнийг нэр дэвшүүлж, материалыг Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

2021 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр аймгийн Засаг дарга Г.Батзам Говьсүмбэр аймгаас Дорноговь аймагт оторлож байгаа 13 өрхийн малчидтай уулзан өвөлжилтийн байдалтай танилцлаа. Тус уулзалтаар малчдад хэрэгцээтэй төрийн мэдээллийг өгч, тулгамдаж буй асуудал дээр санал солилцон, цэцэрлэгийн болон сургуулийн насны хүүхдүүдэд сургалтын материал, хичээлийн хэрэгсэл, аймгийн өвс тэжээлийн нөөцөөс өрх бүрт 10 боодол өвс олголоо. Мөн аймгийн Нэгдсэн эмнэлгээс иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн.

Хүнсний дэлгүүр, үйлдвэрлэгчдийг бүтээгдэхүүнээ татан авах, нөөцлөх, үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх боломжийг ханган Шадар Сайдын 2020 оны 142 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хүнс, нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх, түгээхэд баримтлах түр журам”-ын дагуу 2021 оны 1 дүгээр сарын 19-ний байдлаар 26 ачаа илгээгч, тээвэрлэгчийн тээврийн хэрэгслийг тээвэр зуучийн нэгдсэн цахим санд бүртгүүлж, хүнс болон нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийг хэвийн үргэлжлүүлж байна. Хүнсний бараа, бүтээгдэхүүний татан авах ажиллагааг QR код бүхий жолооч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулж, Улаанбаатар хотоос шинжилгээний хариуг үндэслэн аймагт нэвтрүүлэн, 7 хоног гэрийн ажиглалтад байхаар зохицуулан, хяналт тавьж ажиллаж байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас эрүүл ахуй, халдвар хамгаалал, Хүнсний чанар, стандартын хяналтын чиглэлээр коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх халдвар хамгааллын дэглэмийн шаардлагыг мөрдөж байгаа эсэхэд Баянтал, Шивээговь сумын худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа 29 газрыг хамруулан хяналт шалгалт хийж, шалгалтаар халдвар хамгааллын дэглэм мөрдөж ажиллах тухай 40 заалт бүхий улсын байцаагчийн зөвлөмжийг 4 газарт өгч, цаашид зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах талаар мэдэгдэл хүргүүлсэн.

### ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2021 оны 1 дүгээр сарын Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 506349.0 мян төгрөг төвлөрүүлэхээс, 101315.0 мян төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна.

**Статистикийн чиглэлээр:** Хүн, мал тэжээвэр амьтад, хашаа, худаг, тэжээлийн тооллого 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс 26-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тооллогын урьдчилсан дүнгээр хүн ам 17754 болж, өмнөх оноос 1.8 хувиар өссөн бол 5061 өрх тоологдож өмнөх оноос 1.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Малын тоо 450258 болж өмнөх оноос 0.8 мянгаар буурсан байна. Мал тооллогын урьдчилсан дүнг 5 төрлөөр харуулбал адуу 22688, үхэр 16338, тэмээ 1092 хонь 218054, ямаа 192086 байна.

**Санхүүгийн хяналт аудитын чиглэлээр:** Аймгийн хэмжээнд хяналт тавьдаг 81 байгууллагын 2020 оны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 90.8 хувьтай байна.

**Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэвэр**

№	Төрөл	2020.01.25		2021.01.25	
		Хүний тоо	Тэтвэрийн дүн /мян, төг/	Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян. төг/
1	Өндөр настан	1748	717865.3	1878	935897,6
2	Тахир дутуу	371	101870.0	324	107115,2
3	Тэжээгчээ алдсан	134	39832.2	121	41104,3
4	Үйлдвэрийн осол	27	11523.1	42	23133,3
<b>Нийт дүн</b>		<b>2280</b>	<b>871090,6</b>	<b>2365</b>	<b>1107250</b>

**Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж**

№	Төрөл	2020.01.25		2021.01.25	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян. төг/	Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян. төг/
1	ХЧТА тэтгэмж	63	8605.9	30	3806.5
2	ЖБА тэтгэмж	16	22713.9	23	48681.7
3	Оршуулга	3	3000.0	6	6000.0
4	ҮОМШӨ-ХЧТА	0	0	2	1696.3
5	Ажилгүйдэл	52	32524.1	27	15133.0
<b>Нийт дүн</b>		<b>134</b>	<b>66843.9</b>	<b>88</b>	<b>75317.5</b>

**Сайн дурын даатгал:**

Сайн дурын даатгалын хамрагдалт	2020.01.25	2021.01.25
Шинээр	150	57
Мөнгө тушаасан	252	125
Тушаасан мөнгөн дүн / мян төг/	22683,5	9738,5

**ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Иргэний бүртгэлийн чиглэлээр:**

- Шинээр гадаад паспорт захиалсан - 4
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 41
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо - 20
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо- 4
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо- 3
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо - 1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо- 5
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн - 8
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо- 58

**Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:**

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 5
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 15
- Гэрээний бүртгэл - 21
- Барьцааны гэрээний бүртгэл -104
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 2

### **Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:**

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 1
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 26
- Татан буугдсан хуулийн этгээдийн бүртг - 1

### **Архивын чиглэлээр:**

- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 26
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 77

**Цагдаагийн хэлтэс нь:** 2021 оны 01 дүгээр сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 95 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгасан байна. Урд оны мөн үеэс гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 5-аар буюу 17.8 хувиар буурч, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 42-оор буюу 1.4 дахин өсч, нийт гомдол мэдээлэл 37-оор буюу 63.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Авто тээврийн төв, Тагнуулын хэлтэстэй хамтран “Согтуу”, “Хулгайн зам” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 3, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 3, хорио цээрийн дэглэм зөрчсөн зөрчлүүдийг илрүүлэн шалгаж байна. Мөн замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн 509 иргэнийг Зөрчлийн тухай хуулиар 15211500 төгрөгөөр торгож арга хэмжээ тооцсон.

**Шүүхийн шинжилгээний алба нь:** Хэргийн газрын үзлэгт 19 удаа оролцсоноос хүний амь эрсэдсэн хэргийн газрын үзлэгт 1, зам тээврийн ослын 6, хулгайлах гэмт хэрэг 2, бусад хэргийн газрын үзлэгт 10 удаа, хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 325 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих анги нь:** Тайлант сард хүмүүжигчдийн авьяас, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор 19 төрлийн дугуйланд 171 хүмүүжигчийг хамруулсан.

2021 оны 1 дүгээр сард төлбөрийн 137 гүйцэтгэх баримт бичгээс 12 гүйцэтгэх баримт бичгийн 130749.4 мянган төгрөгний бодит биелэлт 8.7 хувьтай байна.

**Мэргэжлийн хяналтын газар нь:** Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар илрүүлсэн зөрчлийн шинжтэй 3 зөрчилд нийт 400000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, торгуулийг бүрэн барагдуулсан.

Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа явуулж буй ачилт буулгалтын талбай болон гаалийн хяналтын талбайд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудад “Халдвараас сэргийлэх арга хэмжээ авч ажиллах тухай” 24 заалт бүхий улсын байцаагчдын хамтарсан зөвлөмж, Монгол улсын шадар сайд, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн “Уул уурхай бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах түр журам” болон Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/537 дугаар тушаалаар батлагдсан “Хамгаалах хувцас, хэрэгсэл хэрэглэх заавар”-ыг тус тус хүргүүлж үйл ажиллагаанд 5 удаагийн дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч болон аж ахуй нэгж байгууллага, иргэний хүсэлтээр ирүүлсэн усны 9, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний 10, хоол 16, ариутгалын бодис 9 нийт 44 сорьцод 191 үзүүлэлтээр химийн шинжилгээг гүйцэтгэсэн. Эерэг үзүүлэлт илрээгүй.

**Онцгой байдлын газар нь:** Сүмбэр суманд үйл ажиллагаа явуулж байгаа томоохон худалдааны төвүүдэд Ковид-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийн дагуу хяналт

шалгалт зохион байгуулан илэрсэн зөрчил дутагдалд гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн мэдэгдэл хүргүүлэн, биелэлт хяналт тавин ажиллаж байна.

### **ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Боловсролын чиглэлээр:** Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг 2-5 насны хүүхдэд зориулсан “Тост боржигины бяцхан үрс” сургалтын хөтөлбөрийг сурталчлах зорилгоор “Боржигин ёс заншил”-ын талаар цахим хичээл бэлтгэж, хүүхэд багачуудад хүргэсэн.

Теле хичээлийн хэрэгжилт, цахим хичээлийг бэлтгэж, хүүхдэд хүргэх арга туршлагын талаар хэлэлцүүлгийг зохион байгуулан, цэцэрлэг, сургуулийн захирал, эрхлэгч, арга зүйч, багш нийт 166 албан хаагчийг хамруулсан.

1 дүгээр сарын 10-14-ний өдрүүдэд цэцэрлэг, сургуулийн багш нарын дунд эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, шалгарсан 14 илтгэлээс “Боловсролын хүрээлэн”-тэй хамтран 8 илтгэлийг шалгаруулсан.

**Биеийн тамир, спортын чиглэлээр:** Аймгийн Биеийн тамир, спортын салбарын төрийн болон төрийн бус байгууллагын цахим сургалт, зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа спортын 11 салбар холбоод оролцсон.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:** Өсвөр үе залуучуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Хөгжлийн хөтөч” уран илтгэлийн цахим уралдааныг 2021 оны 1 дүгээр сарын 8-ны өдрөөс 2 дугаар сарын 8-ны хооронд зохион байгуулж байна.

#### **Эрүүл мэндийн чиглэлээр:**

Үзүүлэлт	2020 оны 01 сар	2021 оны 01 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	42	23
Гэрийн төрөлт	0	0
Амьд төрсөн хүүхэд	43	24
Амьгүй төрөлт	0	0
Нас баралт	5	3
Эмнэлгийн нас баралт	2	0
Хоног болоогүй нас баралт	0	0
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	0
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	579	53
Амбулаторийн үзлэг	10 186	3 251
Халдварт өвчин	14	0

Коронавируст халдварын нөхцөл байдлын мэдээг өдөр бүр гаргаж, цахим хуудсанд байршуулж иргэдэд мэдээлж байна. Тайлант сард 4 удаагийн тандалтын шинжилгээнд 765 хүнийг хамруулан сорьц авч, ХӨСҮТ-д илгээн шинжилгээний хариу бүгд сөрөг гарсан. Тандалтыг 2 хэлбэрээр явуулж байгаа ба хүн амд суурилсан тандалтад 357 хүн, эмнэлэгт суурилсан тандалтад 408 хүн хамруулсан байна.

Дэлхийн эрүүл, мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яамтай хамтран "Анхан шатны тусламж, үйлчилгээг сайжруулах нь" төслийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталж, удирдамжийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулж эхлээд байна. Төслийн хүрээнд 10000 ам.долларт төсөвт анхан шатны тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг Дэлхийн эрүүл, мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яам зохион байгуулж байна.

Эрүүл мэндийн яам, Нүүр ам судлалын зөвлөлтэй хамтран Шивээговь сумын эрүүл мэндийн төвд байгуулах шүдний кабинетын засварын ажил хийгдэж байна. Цаашид тус сумын эрүүл мэндийн төвийн шүдний кабинетыг улсын хэмжээнд жишиг болгохоор зорин ажиллаж байгаа юм.

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр:** Тайлант сард 4 аж ахуй нэгж, байгууллагаас 10 сул ажлын байрны захиалга ирүүлсний дагуу 5 иргэнийг байнгын ажлын байранд зуучлаад байна.

Ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй, их дээд болон мэргэжлийн боловсролын сургууль төгссөн 14 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгч, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

Нийгмийн халамжийн тэтгэвэр 263 иргэн хамрагдаж 71,8 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 235 иргэнд 21,1 сая төгрөг, амьжиргааг дэмжих тэтгэмжийг 49 иргэнд 14,6 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тусламж, хөнгөлөлтийг 47 иргэнд 1,0 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс” энэ сард 1 удаа хуралдаж, 4 хүүхдийн асуудлыг хэлэлцэж, байнгын асаргааг шинээр тогтоож эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлсэн.

### ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Аймаг дундын Малх отрын бүс нутагт 7 аймгийн 31 сумын 166 малчин өрхийн 187.5 мян.толгой мал оторлож байна. Мөн отрын бүсээс гадна Улаанбаатар хот, Төв, Дундговь, Өвөрхангай, Баянхонгор аймгийн 88 өрхийн 69.3 мян.толгой мал отроор өвөлжиж байна.

Манай аймгаас Улаанбаатар, Дорнод, Дорноговь, Хэнтий, Төв, Сэлэнгэ, Дундговь, Сүхбаатар аймагт нийт 44 өрхийн 33.2 мян.тол мал отроор өвөлжиж байна. Дорноговь аймгийн зарим сумын нутагт отроор өвөлжиж байгаа 13 малчин өрхөд аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцөөс 130 боодол өвсийг тусламжаар үнэгүй хүргэсэн.

Сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг задалж, хөнгөлөлттэй үнээр өвсийг малчин өрхүүдэд олгож байна.

Сумын нэр	Өвс, тэжээлийн нөөц			
	Бэлтгэсэн		Үлдэгдэл	
	Өвс /тн/	Тэжээл /тн/	Өвс /тн/	Тэжээл /тн/
Баянтал	22	15	3.6	1.1
Сүмбэр	50	16	0	16
Шивээговь	6.2	0	6.2	0
Дүн	78.2	31	9.8	17.1

Малын хорогдол 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар дараах байдалтай байна.

№	Сумын нэр	Оны эхний мал	Хорогдсон мал						Нийт малд эзлэх хорогдолын хувь
			Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
1	Баянтал	69934	385			1	5	379	0.6
2	Сүмбэр	322066	667		5	3	311	348	0.2
3	Шивээговь	59226	600		5	2	236	357	1.0
	Дүн	451226	1652	0	10	6	552	1084	0.4

Аймгийн хүнсний бодит нөөцийн хэмжээ: Мах 78.6 тн буюу 47, гурил 82.5 тн буюу 59, сүү 3.9 тн буюу 2, төрөл бүрийн будаа 37.8 тн буюу 54, төмс 29.7 тн буюу 18, хүнсний ногоо 23.1 тн буюу 6, элсэн чихэр 4.8 тн буюу 11, давс 2.6 тн буюу 9, савласан ус 44.3 тн буюу 2, өндөгний нөөц 0.4 тн буюу 1, ургамлын тос 7.2 тн буюу 23 хоногийн нөөцтэй байна.

2021 оны 1 дүгээр сарын байдлаар Сум хөгжүүлэх сангаас зээл олгогдоогүй бөгөөд зээлийн үлдэгдэлтэй 152 зээлдэгчийн 1.0 тэрбум төгрөг байна. 2021 оны 1 дүгээр сард төвлөрүүлэх 22.0 сая төгрөгөөс 1 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 12 иргэний 17.7 сая төгрөг төвлөрч, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 114 зээлдэгчийн 767.2 сая төгрөг байна.

**Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2021 оны 1 дүгээр сарын үнийн мэдээ:**

Зах зээлд худалдаалагдаж буй төмс 100 төгрөгөөр, сонгино 50 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

№	Бараа бүтээгдэхүүн		Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан
1	Үхрийн мах	Ястай	8500	8000	-
		Цул	10500	10000	-
2	Хонины мах	Ястай	6500	6000	-
		Цул	9000	8000	-
3	Адууны мах	Ястай	6000	5500	-
		Цул	6500	6000	-
4	Ямааны мах	Ястай	6000	5500	-
		Цул	6500	6000	-
5	Тахианы мах	Гуя	10500	7900	
		мөч	8000	7900	
6	Лууван	Монгол	1500	1100	-
		Хятад			
7	төмс	Монгол	1200	900	+100
		Хятад			
8	Байцаа	Монгол	800	600	-
		Хятад			-
9	Чинжүү	Монгол	7500	7000	-
		Хятад	6500	4500	
10	Манжин	Монгол	2000	1500	
		Хятад			-
11	Сонгино бөөрөнхий	Монгол	2600	2300	+50
		Хятад	1500	1400	-
12	Улаан лооль	Монгол	6000	5500	-
13	Өргөст хэмх	Монгол	7500	6500	-
14	Элсэн чихэр	Монгол	2200	1600	-
15	Будаа	Цагаан задгай кг	2600	2400	-
		Шар слава кг	3500	3000	-
		Гурвалжин будаа кг	3800	2200	-
16	Сүү	Задгай	3200	3000	-
		Сүү ХХК 0,5л			

		Сүү ХХК 1л	3200	2900	-
17	Тараг	Задгай	2200	2000	-
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-
18	Талх	Чойр талх	1200	1150	-
19	Өндөг	ОХУ	400	360	-
		Монгол	400	330	-
20	Алтан тарианы гурил	Задгай дээд	1520	1480	
		Задгай 1-р зэрэг	1140	1100	-
		Задгай 2-р зэрэг	1000	950	-
		Савласан д/дээд /	2400	2300	-
		Савласан дээд	2200	2100	-
		Савласан 1-р зэрэг	1400	1300	-
		Савласан 2-р зэрэг	1500	1450	-
21	Ургамлын тос	Олейна	5500	5200	-
		Алтан	4500	4500	-
22	Гоймон	Алейка	1800	1600	-
		А/тариа савхан	1100	950	-

### **ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Байгаль орчны чиглэлээр:** Сумын туурь хог хаягдлыг цэвэрлэх, төв хогийн цэгийн орох, гарах гарцыг нээх ажлыг зохион байгуулан, 1 га талбайн 40 тн ахуйн болон барилгын хог хаягдлыг цэвэрлэн булж тэгшилсэн.

Ус цаг уур орчны шинжилгээний төвөөс 1 дүгээр сард найман хугацааны мэдээг нийт 248, климат агро дундаж мэдээ ХАА-н тойм, 10 хоногийн тойм мэдээг нийт 3, сарын тойм мэдээг 1 удаа тус тус дамжуулсан.

Энэ сард азотын давхар исэл (NO<sub>2</sub>) болон хүхэрлэг хийн давхар ислийг (SO<sub>2</sub>) хоногт 3 удаагийн давтамжтайгаар сорьцыг 39 удаа мөн 13 удаагийн дээжинд шинжилгээ хийсэн дундаж азотын давхар исэл (NO<sub>2</sub>) 0.017 мкг/мг, хүхэрлэг хийн давхар исэл (SO<sub>2</sub>) 0.023 мкг/мг байгаа нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

**Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар:** 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Төлөвлөлтийн программд бүртгэн оруулж, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраар баталгаажуулсан.

Газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 2021 оны газрын төлбөрийн ногдуулалт, газрын төлбөрийн нэхэмжлэхийг Сүмбэр суманд 74 нэгж талбарт 174 нэхэмжлэх, Шивээговь суманд 53 нэгж талбарт 106 нэхэмжлэх, Баянтал суманд 59 нэгж талбарт 118 нэхэмжлэх тус тус үүсгэн татвар төлбөрийн дундын мэдээллийн санд илгээсэн.

Хаягийн мэдээллийн нэгдсэн системд оруулах ажлыг 3 сумын хэмжээнд 2021 оны 1 дүгээр сарын 4-19-ний өдрүүдэд нийт 1709 нэгж талбар, 222 барилга, 541 гудамжны мэдээллийг холбож, засварласан.

**Худалдан авах ажиллагааны талаар:** Төсвийн ерөнхийлөн захирагчаас 2021 онд нийт 1640405.5 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 15 бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг гарган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнээс 8 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан байна.

2021 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 8 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 5 ажлын тендер шалгаруулалтыг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 5 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 2 ажлын тендер

шалгаруулалтыг, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 1 ажил төлөвлөснөөс 1 ажлын тендер шалгаруулалтыг тус тус зарлаад байна.

Зарлагдсан тендерийн урилгуудыг “Монголын үнэн” сонин, [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [govisumber.gov.mn](http://govisumber.gov.mn) сайтуудад тухай бүр нийтэлж, тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр явуулж байна. Тендер шалгаруулалты үр дүнг тухай бүрт нь цахим системд оруулсан.

**Орон нутгийн өмчийн талаар:** Орон нутгийн харилцааны асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг тухай бүр өгч, байгууллагуудын 2020 оны хөрөнгийн хөдөлгөөнд хяналт тавьж, жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулан, 2020 онд 43 хуулийн этгээдтэй байгуулсан гэрээг дүгнэн, 43 хуулийн этгээдтэй “Өмч эзэмшүүлэх гэрээ”-г байгуулсан.

### **ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР**

**Баянтал сум:** Сумын онцгой комиссын 3 дугаар хуралдаанаар нөөцөд байгаа өвс, тэжээлийг малчин өрхүүдэд тараах шийдвэр гарч, 1 өрхөд 6 боодол өвс, 1 шуудай тэжээл олгож байна.

2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуусанд байршуулсан.

Баянтал сумын Эрүүл мэндийн мэндийн төвөөс зохион байгуулсан Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэд хөдөлмөрчдөд цахимаар мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгаа, зөвлөмж зөвлөгөөг хүргэж байна.

**Шивээговь сум:** Сумын Засаг дарга, аймгийн Улаан загалмайн хороо, сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран хөдөөгийн малчин өрхүүдийн өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцаж тэдэнд тулгамдаж буй асуудлын талаар санал солилцон, цэцэрлэгийн болон сургуулийн насны хүүхдүүдэд сургалтын материал, хичээлийн хэрэгсэл, улаан загалмайн хорооноос хүнсний болон ахуйн хэрэглэл, дулаан гутал хувцас олгож, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж, эмийн сангийн үйлчилгээ үзүүлсэн. Мөн аймгийн аюулгүйн нөөцөөс хямдралтай үнээр 108 өрхөд 750 гаруй боодол өвс олгоод байна.

Сумын Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.

Суманд отроор 24 малчин өрхийн 444 бод, 15171 бог, нийт 15615 толгой мал өвөлжиж байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан Коронавирусийн үед ажиллах бэлэн байдлыг хангах 6 өдрийн цахим сургалтанд албан хаагчдыг бүрэн хамруулсан.

**Сүмбэр сум:** Японы хүүхдийн ивээх сангийн хэрэгжүүлж буй орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох хөтөлбөрийн сургагч багш нарыг сонгох цахим хурлыг зохион байгуулж, 1-р сургуулийн 5 багшийг 4 жилийн хугацаанд ажиллуулахаар болсон.

Аймгийн Онцгой комиссд хандивласан Бүрэн урлан ХХК-иас хандивласан 1000 ширхэг маскыг сумын зорилтот бүлгийн 5-аас дээш ам бүлтэй нэн ядуу 85 өрхийн 500 иргэнд олгосон.

Сумын аюулгүй нөөцөөс 4, 5, 6 дугаар багийн нийт 209 өрхөд 2075 боодол өвсийг тараасан.

### **ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**